



ОУИТБС-ын Ажлын хэсэг, ажлын алба Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал суманд ажилласан тайлан

2015 оны 6 дугаар сарын 9-ний өдөр

ОУИТБС-ын Ажлын хэсэг, ажлын алба 2015 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Сэлэнгэ аймгийн Баянгол суманд ОУИТБС-ын нээлттэй өдөрлөг, 6-ны өдөр Сэлэнгэ аймгийн Мандал суманд Дархан-уул, Орхон, Сэлэнгэ, Булган аймаг, зарим сумдын төлөөлөлтэй хамтран хойд бүсийн чуулганыг зохион байгууллаа.

Эрдэс баялгийн салбарын талаарх орон нутгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, ОУИТБС-ын тайлангаар ил тод болсон мэдээллийг иргэдэд мэдээлэх, ил тод, хариуцлагатай уул уурхайн талаар нэгдсэн ойлголтыг бий болгох, дэд зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн харилцан ойлголцол хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд эдгээр арга хэмжээний зорилго ньоршиж байв.

Баянгол сумын өдөрлөгт ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны дарга хатагтай Клэйр Шорт, бүсийн захирал Ваутер Бистербос, Алекс Горди нар оролцов. Улаанбаатар хотоос Ашигт малтмалын газар, Татварын ерөнхий газар, Стандартчилал хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын алба, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Төлсөн авснаа нийтэл эвслийн 7 төлөөлөл, ОУИТБС-ын ажлын алба, Монголиан майнинг журнал, Үндэсний шуудан сонины сэтгүүлч, Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын 2 мэргэжилтэн, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэд захирал зэрэг нийт 21 хүний баг, бүрэлдэхүүнтэй оролцов.

Орон нутгийг төлөөлөлж Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч Н.Батдорж тэргүүтэй Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Татварын хэлтсийн дарга, ММЭ ТВ-ийн 2 сэтгүүлч, сумаас Баянгол сумын засаг дарга Б.Энхбат, ойн сангийн нөхөрлөл, төсвийн байгууллага, бичил уурхайчид, нутгийн иргэдийн төлөөлөл бүхий 38 иргэд, компаниудыг төлөөлж Бороо гоулд ХХК, Шижир талст ХХК, Гоби эксплорэйшн ХХК, Сэлэнгэ минералс ХХК, Тод ундарга ХХК, Эрдэс майнинг ХХК, Дунтрейд ХХК, Эм Жи Эл ХХК зэрэг 12 компанийн төлөөлөл оролцов. Бүртгэлийг хавсаргав.



Өдрийн эхний хагаст ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны дарга хатагтай Клэйр Шортын айлчлалын баг болон Ажлын хэсгийн төлөөлөгчид Бороо гоулд ХХК-ийн үйлдвэр дээр очиж байгаль орчны нөхөн сэргээлт хийсэн байдал, нуруудан уусгах технологиор бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үйл явцтай газар дээр нь танилцаж, тус компанийн эдийн засагт болон орон нутгийн хөгжилд оруулсан хувь нэмрийн талаар танилцуулга сонсож, компанийн байр суурьтай танилцав.

Үргэлжлүүлэн 14:00 цагт Баянгол сумын Соёлын төвд Баянгол сумын иргэд, тус суманд тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуйн нэгжүүдтэй ОУИТБС-ын өдөрлөг, уулзалтыг зохион байгуулллаа.

Хөтөлбөрийн дагуу өдөрлөгийг сумын засаг дарга Д.Энхбат нээв. Удаагаар ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны дарга хатагтай Клэйр Шорт оролцогчдод хандан үг хэлэв. Бүсийн захирал Ваутер Бистербос, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч Н.Батдорж нар ОУИТБС-ын дэлхий дахинд, Монгол улсад, орон нутагт хэрэгжиж буй талаар мэдээлэл хийж, Төлсөн авснаа нийтэл эвслийн зохицуулагч Д.Эрдэнэчимэг иргэд юу мэдэхийг хүсдэг талаар, Бороо гоулд ХХК-ийн олон нийттэй харилцах менежер Ч.Энхтуул тус компанийн зүгээс сумын хөгжилд оруулсан хувь нэмрийн талаар, Баянгол сумын засаг дарга Д.Энхбат компаниудаас хүлээн авсан хандив, дэмжлэгийг юунд зарцуулсан талаар тус тус мэдээлэл хийв. Мэдээлэл, сонсголын дараагаар оролцогчдын дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлээ.

Хэлэлцүүлгээс гарсан асуулт, саналыг хураангуйлбал:

Сумын засаг дарга Б.Энхбат тус суманд 34 компани тусгай зөвшөөрөл эзэмшдэг боловч Бороо гоулд, Сонор трейд, Шижир талст гэсэн 3 компани л олборлолтынүйл ажиллагаа явуулсан, тэр утгаараа эдгээр 3 компани л сум орон нутагтай харилцаж буй талаар дурьдав.

Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд уул уурхайн компаниудыг хэдийгээр үйл ажиллагаа нь эхлээгүй ч одооноос сум, орон нутгийн иргэдтэй нь харилцах, боломжоороо тэдний тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахыг уриалав.

Сорьцын албаны мэргэжилтэн С.Бүрэнтогтох тус суманд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан хуваарилдаг хөрөнгийг юунд зарцуулдаг, уул уурхайтай сум гэдгээрээ арай илүү хөрөнгө хуваарилж авах тогтолцоо байгаа эсэхийг тодруулав.

Сумын засаг дарга Б.Энхбат тийм тогтолцоо байхгүйг дурьдаад Төсвийн тухай хуульд заасны дагуу хөрөнгийг хүлээн авдаг, олборлолтын үйл ажиллагаа ид явагдаж байх үед 320 орчим сая төгрөгийг, энэ жил 70 орчим сая төгрөг ОНХСанд хүлээн авахаар төлөвлөснөө дурьдав.

Булган аймгийн Бүрэгхангай сумын ИТХ-ын дарга С.Загас хэлэлцүүлгээс олон шинэ санаа олж авснаа, ялангуяа Бороо гоулд компанитай гэрээ байгуулж, орон нутгийн хөгжлийг дэмжих сан тусад нь байгуулан, үр өгөөжтэй төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж буй туршлагыг сайшаав. Бүрэгхангай сумын тухайд уул уурхайн компани лиценз эзэмшдэг л бол үйл ажиллагаа эхэлсэн, эхлээгүй ялгаагүй бүх аж ахуйн нэгжүүд сумын хөгжилд хувь нэмэр оруулдаг гэнэ. Тэрээр “нэг л зүйлийг бодох хэрэгтэй. Манай суманд 10 алтны уурхай, хайгуулын компани байна. Тэдний төлж буй татвар зөвхөн улсын төсвийг бүрдүүлэхэд л хувь нэмэр оруулдаг, суманд төлж буй татвар нь бүгд нийлээд 1,800,000 төгрөг л байдаг. Гэтэл энэ нь зэргэлдээ сумын нохойны татварын тал хувьтай тэнцэж байна. Энэ арай ичмээр тоо юм. Тиймээс тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих үүднээс компаниудтай хууль эрх зүйн орчин асуудалтай ч гэсэн гэрээ байгуулж ажилладаг” гэв.

Бичил уурхайчдын төлөөлөл өнөөдрийн өдөрлөгөөр олон асуудлуудыг хөндөж байгаад баяртай байгаагаа илэрхийлээд хоёр зүйл дээр саналаа хэлэв. “Нэгдүгээрт, Ашигт малтмалын газрын эрх дэндүү давуу, түрэмгий байна. Орон нутагт



ямар ч эрх мэдэл алга. Компаниуд аймагтайл харьцдаг, орон нутагтай харьцдаггүй, нэг мэдэхэд л биднийг хөөдөг, малыг усгүй болгодог, газрыг ухдаг, хууль хяналтын баг бүрдүүлж ирээд бидний эрхэнд халддаг. Мэдээлэл өгдөггүй. Энэ байдалд өөрчлөлт хиймээр байна. Хоёрдугаарт, ард иргэд ажилгүй, орлогогүй байна. Бид хориод жил гар аргаар алт олборлолоо. Энэ арга барил нь хүй нэгдлийн үе шиг гээгдсэн, хаягдсан алтыг л хайж, олж, ашигладаг. Ядуурал ихсэж байна. Орон нутгийн удирдлагууд компанийн эрх ашгийг хамгаалж байдагт гомдолтой байдаг, хууль, тогтоомж компанийн эрх ашгийн төлөө л гардаг. Сонор трейд гэдэг компани маш их олборлолт хийдэг, гэтэл манай сумаас нэг ч ажилтан авдаггүй, тусгай вант улс байдаг, орон нутгийн иргэдтэй харьцдаггүй, яагаад ийм тусгай эрхтэй юм бэ? Сэлэнгэ минералс компанийн асуудал байна. Тэдний тусгай зөвшөөрөл авсан талбайд 15 бичил уурхайн нөхөрлөл ажиллаж байдаг, тэдний ард 400 хүн амь зогоож байдаг, гэтэл өнөөдөр талбайг булаацалдаад шүүхэд биднийг өгсөн. Сумын засаг дарга та энэ асуудалд хариулт өгөөчээ, Яагаад та ард иргэдээ хайрлаж, хамгаалдаггүй юм, яагаад компанийн төлөө ажиллаад байна аа?”

Сумын засаг дарга Б.Энхбат тайлбар хийв. Тэрээр “сумын засаг дарга хууль хэрэгжүүлэх л үүрэгтэй. Хайгуул хийх гээд компани төлөвлөгөөгөө бариад ирэхэд байгаль орчны төлөвлөгөөг нь батлах л үүрэгтэй. Сэлэнгэ минералс компанийг ямар ч байдлаар хаацаалаагүй. Харин аль 2000 оноос манай сумын үе үеийн удирдлагууд бичил уурхайчдад дэмжлэг үзүүлдэггүй юмаа гэхэд гай болчихгүй юмсан гэж явж ирсэн, бүгд мэдэж байгаа. Бодит байдал ийм л байна. Сэлэнгэ минералс компанийн талбай дээр манай сумын бичил уурхайчид 100 гаруй метр ухаад олборлочихсон байгаа. Компани өнөөдөр намайг ард иргэдийнхээ энэ хууль бус үйл ажиллагааг яагаад хамгаалаад байна аа гэдэг. Удахгүй намайг шүүхэд өгөх байх. Нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулах гэж олон жил явж ирлээ. Сонор трейд компанийн хувьд үндсэн ордны компани. Төрийн зүгээс компанид дарамт шахалт үзүүлэхийг оролддоггүй, хуулийн хүрээнд ажиллахыг эрмэлздэг. Харин жилд нэг удаа сар шинээр ахмадуудад хүндэтгэл үзүүл гэж албан тоот явуулдаг. 34 аж ахуйн нэгжээс бид арай хийж 50%-г нь олж авдаг, бусад аж ахуйн нэгжүүд бүртгэлтэй яваад л байдаг. Ямар нэг байдлаар хамгаалсан зүйл байхгүй ээ. Харин Шижир талст компани сайн дураараа нийгмийн хариуцлагын хүрээнд 1 га газрыг моджуулъя гээд ирсэн, манай суманд тусгай зөвшөөрөл эзэмшиж буй бүх аж ахуйн нэгжүүдтэй 1-р улиралд уулзалт хийхээр төлөвлөсөн боловч хийж чадаагүй байна.” гэв.

Г.Чагнаадорж: Хоёрхон компаниас хандив авсан гээд байна. Танай сумын ОУИТБС-ын 2013 оны тайлан дээр 6,2 тэрбумын хандив өгсөн гэжээ, та бусдыг нь тайлагнахгүй байна уу? ямар учир байна? Хувийн бодлоо хуваалцахад сум, орон нутгийн удирдлага бичил уурхайчдад нөхөрлөл болж ажиллахад дэмжлэг үзүүлэх тал дээр дутмаг юмуу гэж бодлоо. Бороо гоулд компанийн талбай дээр иргэдээ оруулж нөхөн сэргээлт хийлгэж болдоггүй юмуу? Ер нь энэ хандив дэмжлэгийг сумын ой, бөх, баяр наадамд битгий авч байгаачээ, ард түмний эрүүл мэнд, сайн сайхны төлөө хандив өгч, авдаг байгаачээ гэж хэлмээр байна.

Сумын засаг дарга Б.Энхбат: Бороо гоулд компани хандив өгөхдөө нийтийн эрх ашиг хөндсөн тийм зүйлд өгнө гэсэн бодлого баримталдаг. 2012 оноос хойш Шижир талст, Бороо гоулд, Сонор трейд энэ 3 л олборлолт хийсэн. Бичил уурхайчдыг дэмжих асуудал тавьдаг. Хуульд бол “болно” гэсэн байдаг. Гэтэл энэ нь “болохгүй” ч байж болох утга санаа байгаад байдаг. Бороо гоулд компанид хандахад стратегийн орд учраас боломжгүй гэдэг. Сэлэнгэ минералс компанийн хувьд уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны төлөвлөгөө ирээгүй байхад би асуудал тавьж болохгүй байна. Нөхөрлөлийн зохион байгуулалтад орох эсэх нь тухайн иргэдийн өөрсдийн эрх мэдлийн асуудал. Бичил уурхайчид заавал компанийн тусгай зөвшөөрөлтэй талбай руу орох гээд байдаг, бусад газар дээр санал гаргаагүй. Гаргаагүй байхад нь бид тэнд очиж тэгж ажил гэж хэлэх буруу. Дахин хэлэхэд сумын удирдлага бичил уурхайчдыг аль болох дэмждэггүй юмаа гэхэд хааж боогоогүй.

Сумын иргэний төлөөлөл 34 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл эзэмшдэг юм бол нийлээд бидний үр хүүхдүүдэд үлдэцтэйхэн шиг юм хийгээчээ, ашиггүй лицензийг эзэмшээд байгаад байна гэж байхгүй гэсэн саналыг гаргав.

Иргэний төлөөлөл: Өнөөдрийн өдөрлөгт оролцож буй хатагтай Клэйр Шорт танаа баярлалаа. Олон мэдээлэл олж авлаа. Харамсалтай нь цөөхөн хүн ирсэн байна. Ард түмний амьдрал ядуу байна аа. Бичил уурхай эрхлэгчид аргагүйн эрхэнд бий болж байна. Ийм уулзалтанд цаашид илүү олон хүн оролцуулаасай. Бид мэдээлэл маш муутай байна, 34 аж ахуйн нэгж байдгийг өнөөдөр л мэдэж байна, үүнээс 2 нь л орон нутгийг дэмждэг гэхээр хүмүүс дургүйцэж байна. Үр ашгийг нь хэдэн жилийн дараа хүртэх нь ойлгомжгүй, нөхөн сэргээлт хэдэн жилд хийдэг юм гэх мэт мэдээлэл огт алга байна. Компаниуд нөхөн сэргээлт хийхдээ иргэдийг оролцуулаачээ гэж хүсэх байна. ОУИТБС-ын дэд зөвлөлийг яаралтай байгуулъя, энэ санаачилга манай суманд хэрэгжих ёстой гэж бодож байна.

Бичил уурхайн төлөөлөл: Манай суманд 35 компани байдаг юм байна, цөөхөн нь олборлох үйл ажиллагаа явуулдаг, лиценз хадгалаад байдаг нь ямар учиртай юм? Компаниудын удирдлага уулздаггүй, менежер нь л ирж уулздаг, Бороо гоулд хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг, бид сум орон нутагтаа тодорхой хэмжээнд үр өгөөж хүртээд явдаг.



Иргэдийн дунд шинээр төрсөн 1 хүүхэд бүр 11 сая төгрөгийн өртэй боллоо, Оюу толгой, Таван толгойг гадаадад өгсөн гэх мэт хэвлэл мэдээллээр үнэн худал нь мэдэгдэхгүй бидний тархи толгойг угаасан ийм мэдээлэл явдаг. 2014 оны 9 сараас ОУИТБС гэдэг нам гарч ирсэн. Баруунхараагийнхан бид бол нинжа гэдэг зүйлийн бараг загалмайлсан эцэг гэж хэлж болохоор тийм эрт энэ үйл ажиллагаа руу орсон. ОУИТБС-ын дарга нь Цолмон гуай юм байна. Цолмон гуайг зурагтаар огт харж байгаагүй, өнөөдөр л харж байна. Тэгэхээр таны ажил анхны бичил уурхай бий болсон газар хүрээгүй байна гэхээр ямар хүрээнд хүрч ажиллаж байна вэ? ОУИТБС-ыг хэрэгжүүлэхдээ иргэдийн оролцоог яаж хангах юм гэдгийг илүү сайн тусгаж өгөх хэрэгтэй.

Төлсөн авснаа нийтэл эвслийн гишүүн Л.Бор: Сэлэнгэ аймгийн 3 суманд ОУИТБС-ын дэд зөвлөл байгуулах гээд сүүлийн 2 жил ажиллаж байна. Энэ улсуудын амьдрал байдлыг тодорхой хэмжээнд мэднэ. Ажлын алба бол цөөхөн хүнтэй ч гэсэн маш сайн ажилладаг. Олон улсын төлөөлөгчид ажилтай нь танилцаад сайшааж байна. ОУ-ын төлөөлөгчдөд нөхцөл байдлыг зөв ойлгоосой гэсэндээ дараах зүйлсийг хэлье. Монгол улсад уул уурхайн салбар 20 жил буруу явагдсан. Өнөөдөр иргэдээс огт санал авдаггүй, дээрээсээ бүх шийдвэр гардаг, үндэстэн дамнасан хэдэн компанитай нийлж засгийн газрын байгууллагууд лиценз тараахаас биш зөв голдиролд нь оруулъя, өөрийн үндэсний эрх ашгийг хамгаалъя гэсэн санаа сэтгэл сул байдаг. Энэ суманд 30 алтны уурхай байгаа юм. 2-3 компани бид нартай харьцаж ирдэг, хүмүүс нь ажилгүй, ядуу, гэтэл уурхайны тоо нь өсөөд байдаг, амьдрал ахуй нь дээшилдэггүй иймүрвүү хамааралтай яваад байдаг. Сэлэнгэ бол монголын ойн сан, усан сан бүхий сайхан газар нутаг. Энд алтны олборлолт их явагдвал амьдрал хэцүүднэ, өнөөдөр нийт газар нутгийн 80-90% нь цөлжилтийн байдалтай, аюултай хэмжээнд байгаа, 2030 он гэхэд усны хомсдолтой болно. Тэгэхээр Сэлэнгийн район бол биднийг ундаалах ийм газар нутаг байгаа юм. Уул уурхайн компаниуд орон нутагтай холбоогүй ажиллаж ирсэн энэ дээр анхаарах хэрэгтэй.

Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Ц.Жаргалнэмэх: Ард иргэд бухимдалтай байдаг нь мэдээлэл бага байдгаас гэж үзэж байна. Өнөөдрийн байдлаар Монгол улсад 1458 хайгуулын, 1416 ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон байдаг, энэ нь нийт газар нутгийн 7.8% юм. Үүнээс 0,7% нь ашиглалтын лиценз байгаа, үйл ажиллагаа явуулж байгаа 342 аж ахуйн нэгж байдаг, эвдрэлд орсон 26,123 га газрын 12,163 нь техникийн нөхөн сэргээлт хийсэн,

үүний 64% нь биологийн нөхөн сэргээлт хийсэн. Аж ахуйн нэгжүүд орон нутагтай харьцдаггүй гэж байна, гэтэл тэд хайгуулын ажлын төлөвлөгөөг батлуулах гэж заавал орон нутагтай харилцдаг, тэднийг хэлмэгдүүлж болохгүй. Нутгийн иргэд яагаад аж ахуйн нэгжтэй харьцах гээд байдаг юм. Компаниуд та бүгдийн адил монгол улсын иргэд л байгаа, хаана юу байгааг хайж, нөөцөө тогтоож, эдийн засагт ач холбогдолтой байна уу үгүй юу гэдгийг тогтоосны дараа олборлодог, яагаад хааж боогоод байдаг юм? Монгол улс дээрэмчин болсон юмуу? Онги голын ус ширгэлээ гэсэн гомдлын дагуу бид судалсан, уул уурхайн олборлолтоос болоогүй байсан, ард иргэд өөрсдөө мэдээлэлтэй байх хэрэгтэй, өнөөдөр мэдээлэл нээлттэй байна. Заавал нинжатай байх ёсгүй, нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулаад та бүгдийн эрүүл, аюулгүй байдлын төлөө ажилладаг, төр бол бүгд хууль хэрэгжүүлэгчид, хууль зөрчихгүй л ажиллах ёстой. Орон нутгийн удирдлага ард иргэддээ мэдээлэл өгч байх хэрэгтэй.

Бүрэгхангай сумын ИТХ-ын дарга С.Загас: Анхдагч орон нутагт анхаарал хандуулахгүй бол болохгүй нь. Эцсийн бүлэгт анхдагч орон нутгийн амьдралын чанар сайжирсан байх ёстой, байнгын ажлын байраар хангагдаж байх ёстой. Нинжа баймгүй байна, сум орон нутгийн бид компаниудаас өчүүхэн зүйл хүсдэг. Газраараа, агаараараа, усаараа эрсдэл хүлээж байгаагийн хувьд уул уурхайн олборлолт явагдаж буй сумын хөгжил зэргэлдээ сумаас тохой илүү байх ёстой. Компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй ажил нь өөр байгаасай гэж бодож явдаг. Байнгын ажлын байр хангахдаа тааруу шүү. Шалтгаан нь мэргэжлийн хүн байхгүй гэдэг, хүсвэл олон жилийн хугацаанд бодлогоор ажиллах хүчнээ сургаад ажиллуулж болно. Бас нэг зүйл бол компаниуд сум орон нутагт бүтээн байгуулалтын ажил хийж өгдөг, гэхдээ өртөгөө тэд гэж хэлдэг, сумын удирдлага яг тийм зардал гарсан байна уу гээд хянаад явдаггүй. Тэгэхээр ОУИТБС болон иргэний нийгмийн байгууллагууд хөндлөнгийн аудит хийж бодит өртөгийг нь тогтоож өгөөчээ гэж хүсэх байна.

Сэлэнгэ аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Ч.Дэмбэрэлсайхан: Орон нутагт хандсан асуудлуудын зарим нь аймагтай холбоотой байсан тул хариулт өгье. Манай аймаг уул уурхайн салбарт баримтлах бодлого гэж баталсан. Энэ хүрээнд л салбарын үйл ажиллагааг дэмжиж ажиллана. Өнгөрсөн жил Бороо гоулд компаниас өөр компани төлөвлөгөөгөө батлуулаагүй. Байгаль орчны үнэлгээний тухай хуулиар бол компани 10 зүйл бүхий нарийвчилсан төлөвлөгөөг батлуулдаг. Тэгэхээр тусгай зөвшөөрөл эзэмшиж буй компаниудын сум, орон нутагтай харилцдаггүй байдалд анхаарал хандуулах хэрэгтэй. Хоёрдугаарт, Бичил уурхайчдыг хувиараа ашигт малтмал олборлогчидтой хольж ойлгож болохгүй. Аймгийн зүгээс бичил уурхайчдыг статистик мэдээнд оруулж, нэгдсэн журмаар алтаа тушаадаг болгож, өөр ажил үйлчилгээ эрхлэхэд чиглүүлж, сургалтанд хамруулж, малжуулах гэх мэт байдлаар аль болох багасгах бодлого баримталж байгаа шүү.

Хэлэлцүүлгийн төгсгөлд Олон улсын удирдах хорооны дарга хатагтай Клэйр Шорт оролцогчдод хандан хаалтын үг хэлснээр Баянгол суманд зохион байгуулсан ОУИТБС-ын өдөрлөг 18 цаг 20 минутанд өндөрлөлөө.



Хаалтын үг Клэйр Шорт: Орон нутгийн иргэд өнөөдрийн үүлзэлт, өдөрлөгт идэвхтэй оролцоод, тулгамдаж буй асуудлуудаа чөлөөтэй илэрхийлсэн явдалд та бүгдээр бахархаж байна. Нэгэн эрхэм “бидний үр хүүхдүүд үргэлжийн мөнхөд бичил уурхайчид байгаасай гэж хүсдэггүй, гэхдээ өнөөдрийн нөхцөл байдалд аргагүй ийшээ орсон” гэж хэлсэн энэ бол бодит байдал юм. Филиппин улс ОУИТБС-ын тайланд түршилтын байдлаар гар аргаар алт олборлогчдийн мэдээллийг оруулдаг. Энэ нь магадгүй монголын нөхцөлд

туршлага болж болох юм. Ажлын алба удахгүй Филлипинд болох хуралд оролцоно, тэр үеэр туршлага судлаж, багийнхантайгаа хуваалцаарай. Эцэст нь хэлэхэд танай улсад ардчилал сайн бэхэжсэн юм байна, ард иргэд нь чөлөөтэй, шударгаарсаналаа илэрхийлж, удирдлага нь ний нуугүй асуудалд хариулаад, хоорондоо харилцаж, ажлаа шийдвэрлэж чаддаг юм байна. Өнөөдрийн үүлзалт та бүхний харилцаанд хувь нэмэр оруулсан байх гэж найдаж байна. ОУИТБСхэрэгжсэнээрээ үүл үүрхайн салбарыг эцсийн бүлэгт ард иргэдэд өгөөжтэй байлгах явдал юм. Та бүхэнтэй хамт оролцсондоо нэр төрийн хэрэг байлаа, баярлалаа, өнөөдрийн хурлаас үр дүнтэй шийдвэр гаргаж, дэд зөвлөлдөө ард иргэдээ түлхүү оролцуулж байгуулна гэж найдаж байна.

Олон улсын удирдах хорооны дарга хатагтай Клэйр Шортын айлчлалын баг Улаанбаатар хот руу буцаж, ОУИТБС-ын ажлын хэсэг, ажлын алба цааш Мандал сум руу явав.

Хянасан:

Ш.Цолмон

Тайлан бичсэн:

Б.Дэлгэрмаа